

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН АРХИВЫН БАРИМТЫГ ЦАХИМЖУУЛАХ ТӨСӨЛ ЭХЭЛЛЭЭ

2017 - 11-р сарын 02, Пүрэв гариг, 05:46

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг” төслийн “Монгол Улсад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахим систем бүрэн нэвтрүүлэх” дэд хэсгийн төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын цаасан баримтыг цахимжуулах ажил эхэллээ.

Тус архивын баримтыг цахимжилуулах нээлтийн ажиллагаанд ОӨУБЕГ-ын дэд дарга Д.Дэлгэрсайхан, хэлтсийн дарга С.Арман төсөл хэрэгжүүлэгч “Эс Ти Экс Сити Нэт” ХХК болон Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар, Мэдээллийн технологийн газрын багийн ахлагч нар оролцов.



